

**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА,
ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА,
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2021 оны 3 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар А/29, А/24, А/175

Улаанбаатар хот

УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН АНГИЛАЛ, КОД БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын "Улсын бүртгэлийн ерөнхий хууль"-ийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээний ангилал, код"-ыг нэгдүгээр, "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нэгдсэн ангилал, код"-ыг хоёрдугаар, "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нэгдсэн ангилал, код"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Улсын бүртгэлийн нэгдсэн ангилал, кодыг хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газар /Т.Нармандах/, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар /Т.Төгөлдөр/, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар /Б.Ариунболд/, Мэдээллийн технологийн газар /П.Нэргүй/, Үндэсний статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газар /А.Амарбал/, Эдийн засгийн статистикийн газар /Э.Эрдэнэсан/, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Цахим хөгжлийн газар /Л.Энхбат/-т тус тус даалгасугай.

3. Улсын бүртгэлийн нэгдсэн ангилал, кодыг нийтэд мэдээлж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд дарга /Г.Билгүүн/, Үндэсний статистикийн хорооны Дотоод аудит, мониторингийн хэлтэс /Б.Саранчимэг/-т тус тус үүрэг болгосугай.

ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРООНЫ ДАРГА

Б.БАТДАВАА

ХАРИЛЦАА ХОЛБОО,
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ДАРГА

Б.БОЛОР-ЭРДЭНЭ

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА

Д.ДЭЛГЭРСАЙХАН